



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН  
НЭГДЛИЙН ДАРГА Б.ГАНБАТ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

АКТ

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IY байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.12.25 № 02/88

Төсвийн орлого болгох тухай

Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2013 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу “Эрүүл хүүхэд аяны санхүүжилт, үр дүн” аудит хийх явцад тус аяны хөрөнгө болох 710,000 төгрөгөөр эмийн шкаф, 699,000 төгрөгөөр проектер, нийт 1,409,000 (Нэг сая дөрвөн зуун есөн мянган) төгрөгийн бараа материал худалдан авч зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-т “Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг ... зориулалтын бус чиглэлээр ашиглах, байршуулахыг хориглоно”, Сангийн сайдын 73 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журам”-ын 8 дугаар зүйлийн 8.1-д “Төсвийн байгууллага нь олгосон санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулахаас өөр бусад хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулахыг хориглоно”, мөн Эрүүл мэндийн сайдын 2012 оны 2/997 дугаар тушаалыг тус тус зөрчсөн байна.


Иймд Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т “Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх”, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.1-д “...алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэж заасныг үндэслэн ТОГТООХ нь:

1. Зориулалт бусаар зарцуулсан 1,409,000 (нэг сая дөрвөн зуун есөн мянган) төгрөгийг 2014 оны 2 дугаар сарын 1-нд багтаан Нийгмийн даатгалын ерөнхий газрын эрүүл мэндийн даатгалын сангийн 900090003 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Актын биелэлтийг 2014 оны 2 дугаар сарын 10-ны дотор гарган Үндэсний аудитын газарт албан ёсоор ирүүлэхийг Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн дарга Б. Ганбат, ерөнхий нягтлан бодогч Б.Гармаа нарт хариуцуулан акт тогтоов.

АКТ

ТОГТООСОН:



ЗӨВШӨӨРСӨН:

